63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1.00	1.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1.00	1.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18.00	22.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5.00	5.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	8.00
650010	Гэрээт ажилтан	3.00	8.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,339,840.00
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	5,339,840.00
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,339,840.00
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	141,750.00
210,105.00	Гэрээт ажлын хөлс	141,750.00
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,215,363.00
210,301.00	Гэрэл, цахилгаан	2,215,363.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	318,090.00
210,402.00	Тээвэр, шатахуун	318,090.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	2,664,637.00
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	2,664,637.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,339,840.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,339,840.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
131,105.00	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,339,840.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Цагааннуур тосгоны захирагч нь ЗТосгоны оршин суугчид иргэдийн ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн хөгжил, дэвшилд дэмжлэг үзүүлэх, төсвийн байгууллагуудыг оновчтой бодлого, зохицуулалт, бодит мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, үйл ажиллагаа нь аливаа улс төр, үзэл суртлаас ангид байж, гагцхүү Монгол Улсын хууль тогтоомжийг дээдэлж, иргэдийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргахад оршино³ гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил БӨА-2025/010/НА-СТА-ТТЗ

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч 2024 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Цагааннуур тосгоны захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/71 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18.5 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	103431.06	14387.09	-89043.97
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	13316.85	11707.09	-1609.76
Үндсэн хөрөнгө	406970.72	479150.03	72179.31
Нийт хөрөнгө	<u>523,718.64</u>	<u>505,244.22</u>	<u>-18,474.42</u>
Өр төлбөр	1174.45	9631.28	8,456.83
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	522544.19	495612.94	-26,931.24
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>523,718.64</u>	<u>505,244.22</u>	<u>-18,474.42</u>

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 14.4 сая төгрөг болж, өмнөх оноос 89.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	103.4	14.4	89.0
Төгрөг	103.4	14.4	89.0
Төрийн сангийн харилцах	103.4	14.4	89.0
Арилжааны банк дахь харилцах			
Дүн	103.4	14.4	89.0

Эх сурвалж: Аудитын судалгаа.

Оны эцэст Төсвийн ерөнхий орлогын дансанд 0.6 сая төгрөг, ОНХСанд 9.1 сая төгрөг, Сум хөгжүүлэх сангийн дансанд 4.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага данс үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	-	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	-	-	-
Зээлийн авлага	-	-	-
Хувь хүмүүст олгосон зээл	-	-	-
Дүн	-	-	-

сурвалж: Аудитын судалгаа

Авлагын дансны эцсийн үлдэгдэл байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 11.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	6.0	4.6	1.4
Эм боох материал	6.0	4.6	1.4
Бэлэн бүтээгдэхүүн	-	-	-
Хангамжийн материал	7.3	7.1	0.2
Бичиг хэргийн материал	0.03	0.03	0
Аж ахуйн материал	3.0	2.8	0.2
Сэлбэг хэрэгсэл	-	-	-
Түлш, шатах тослох материал	2.4	2.4	0.0
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	1.9	1.9	0.0
Мал амьтад	-	-	-
Дүн	13.3	11.7	1.6

Эх сурвалж: Аудитын судалгаа

Захирагчийн алба 7.1 сая төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 4.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Бусад эргэлтийн хөрөнгө байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 479.1 сая төгрөг болж, өмнөх оноос 72.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	400.3	471.7	71.3
Барилга, байгууламж, орон сууц	261.5	331.8	70.3
Авто-тээврийн хэрэгсэл	23.0	17.8	(5.2)

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Машин тоног төхөөрөмж(компьютер)	28.4	32.4	4.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	5.9	18.4	12.5
Зам, гүүрийн байгууламж	-	-	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	81.5	71.2	(10.3)
Дуусаагүй барилга, байгууламж	-	-	0
Ном	0.03	0.03	0
Биет бус хөрөнгө	6.6	7.5	0.9
Программ хангамж	1.4	2.3	0.9
Бусад биет бус хөрөнгө	5.2	5.2	0
Дүн	406.9	479.1	72.2

Эх сурвалж: Аудитын судалгаа

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 406.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 115.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 43.6 сая төгрөгийн элэгдэл байгуулж оны эцэст 479.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр данс оны эхэнд 1.2 өглөгтэй гарсан ба оны эцэст 9.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	1.2	9.6	8.4
Ажилчидтай холбогдсон өглөг	1.2	5.4	4.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-
Бусад өглөг	-	4.2	4.2
Байгууллагад төлөх өглөг	-	4.2	4.2
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Дүн	1.2	9.6	8.4

Эх сурвалж: Аудитын судалгаа

Захирагчийн алба оны эцэст 9.6 сая төгрөгийн НДШ-ийн болон түлш халаалтын өглөгтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 495.6 сая төгрөг болж, өмнөх оноос 26.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	876.6	876.6	0
Хуримтлагдсан үр дүн	(651.8)	(678.7)	-26.9
Өмнөх үеийн үр дүн	(784.2)	(651.8)	(132.4)
Тайлант үеийн үр дүн	132.4	(26.9)	159.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	297.7	297.7	0
Дүн	522.5	495.6	-26.9

Эх сурвалж: Аудитын судалгаа

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 495.6 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 26.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цагааннуур тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,028.5 сая төгрөгөөр, төсвийн зарлагыг 1.028.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тус сумын ИТХ-аас төсвийг 105.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,133.6 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 874.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 50.0 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 103.4 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Цагааннуур тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 874.8 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд: Орон нутгийн төсвийн орлогоос 824.8 сая төгрөгийн санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сангаас 50.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 866.8 сая төгрөг буюу 88.1 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2023 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 221 дугаар тогтоолоор Цагааннуур тосгоны 2024 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 1,009.5 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын хуралдааны “2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 262 дугаар тодотголоор 1,133.6 сая төгрөгөөр буюу 124.1 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2024 оны 03 дугаар хуралдааны тогтоолоор 2024 орлогын төлөвлөгөөг 1,133.6 сая төгрөгөөр буюу 124.1 сая төгрөгөөр нэмж баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 916.2 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөө 19.2 хувиар буюу 217.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+, бууралт -/-	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	1,108.6	891.9	-216.7	80.4
II.Татварын бус орлого	25.0	24.3	0.7	97.2
Нийт дүн	1,133.6	916.2	-217.4	80.8

Орон нутгийн татварын орлогод 1,108.6 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 891.2 сая төгрөгийн орлого оруулж 216.7 сая төгрөгөөр, татварын бус орлогод 25.0 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 24.3 сая төгрөгийн орлого оруулж 0.7 сая төгрөгөөр тус тус орлого тасарсан байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд цалин хөлс түүнтэй адилтгах орлого 212.2 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 13.8 сая төгрөгөөр, бууны албан татвар 1.0 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1.0 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны татвар 2.0 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 3.4 сая төгрөгөөр тасарч, хөрөнгө борлуулсны орлого 7.0 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 3.7 сая төгрөгөөр, бусад нэр заагдаагүй орлого 2.6 сая төгрөгөөр давж малд ногдуулах албан татвар төлөвлөгдөөгүй боловч 2.5 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 103.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 1,013.3 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, оны эцэст 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын 2024 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Захирагчийн алба	668.4	570.1	98.3
2	Ерөнхий боловсролын сургууль	161.6	158.9	2.7
3	Хүүхдийн цэцэрлэг	55.9	55.9	0.0
4	Соёлын төв	13.6	12.6	1.0
5	Эрүүл мэндийн төв	29.4	27.3	2.1
6	ОНХСан	50.0	41.9	8.1
	Нийт дүн	978.9	866.7	112.2

Захирагчийн албаны төсөв төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь **орон нутгийн орлого тасарсантай** холбоотой байна. ОНХС-гийн төсвийн гүйцэтгэлд 1 төсөл арга хэмжээний ажил дутуу хийгдсэн нь нөлөөлсөн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цагааннуур тосгоны захирагч нь Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд дээд шатны төсвийн захирагчаас нийт 2.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 3.3 сая төгрөгийн нийт 5.3 сая төгрөгийн нэмэлт

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

санхүүжилт хүлээн авч цалин хөлс нэмэгдэл урамшил зардалд 0.1 сая, гэрэл цахилгааны зардалд 2.2 сая, хангамж, бараа материалын зардалд 3.0 сая нийт 5.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цагааннуур тосгоны захирагчийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,072.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 16.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 707.6 сая төгрөгийн 24 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 192.8 сая төгрөгийн 16 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 63.8 сая төгрөгийн 4 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт: Шилэн данстай холбоотой зөрчил гараагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа зөрчилтэй суудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй боловч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар бүх сумын Засаг дарга нарт малын татварын төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” зөвлөмж өгсөн ба малын татварын орлогыг сумын ИТХ-аар батлуулж ажиллаагүй байна.

Цагааннуур тосгонд 2022 оноос татварын байцаагчийн орон тоо хасагдсанаас шалтгаалж малын хөлийн татвар тогтмол авагдаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга хийгдээгүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Захирагчийн алба, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 543.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 306.6 сая

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төгрөгийн алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 12.3 сая төгрөгийн албан шаардлага, 223.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төсвийн байгууллага, 1 тусгай сангийн нийт 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Цагааннуур тосгоны санхүүгийн тайланд “хязгаарлалтай” дүгнэлт өгсөн байна.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Цагааннуур тосгоны Захирагчийн албаны санхүүгийн тайланд “хязгаарлалтай” дүгнэлт, Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сангийн тайланг түүвэрт хамруулж үзсэн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 827.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс: санхүүгийн тайланд 529.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1.5 сая төгрөгийн 2 акт, 594.5 сая төгрөгийн зөрчилд¹ 3 албан шаардлага, 245.4 сая төгрөгийн 14 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4: Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Захирагчийн алба	16	482.4	10	306.6	1	1.3	1	12.3	5	162.2
2	ОНХС	2	61.0							2	61.0
Дүн		18	543.4	10	306.6	1	1.3	1	12.3	7	223.2
2	Эрүүл мэндийн төв	2	756.7	1	177.0			1	579.7		
3	Хүүхдийн цэцэрлэг	2	2.5					1	2.5	1	
4	Соёлын төв	7	64.7	1	42.3	1	0.2			5	22.2
5	ЕБ-ын сургууль	2	3.4	1	3.4					1	
Дүн		13	827.3	3	222.7	1	0.2	2	582.2	7	22.2

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийт дүн	31	1.370.7	13	529.3	2	1.5	3	594.5	14	245.4
----------	----	---------	----	-------	---	-----	---	-------	----	-------

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ТТЗ-ийн харьяа байгууллагуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнах	1							1					
Дүн	1						1						
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								